



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/219

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны VI хуралдааны “Эрүүл Булган хөтөлбөр батлах тухай” VI/32 дугаар тогтоол, 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2026 оны 03 дугаар сарын 19-ний хурлын дагуу “Эрүүл Булган” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих арга хэмжээнд тусгагдсан “Хүн амын дундах хорт хавдрын тохиолдлыг бууруулах чиглэлээр судалгаа, сургалт, сурталчилгааны арга хэмжээ”-ний гүйцэтгэгчээр шалгарсан Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй 78,903,000 (далан найман сая есөн зуун гурван мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Эрүүл мэндийн газар (Д.Нарантуяа)-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан сургалт, судалгаа, нөлөөллийн арга хэмжээг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Л.Баттөр)-д даалгасугай.

3. Тус арга хэмжээний санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу “Эрүүл Булган” хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй.

4. Хүн амын дунд зонхилон тохиолдох хавдрын судалгаа, сургалт, нөлөөллийн арга хэмжээ гэрээнд заасан хугацаанд чанартай, үр дүнтэй зохион байгуулагдаж байгаад хяналт тавьж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ДҮРЭВ-ОЧИР

